



АРХАНГАЙ АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Аудитын код: АРА-2017/165/СТА-ТШЗ

1. Аудитын гэрчилгээ
2. Аудитын тайлан
3. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Тэргүүлэх аудитор: Д.Уламбаяр

Утас: 70333141

Аудитын менежер: Т.Байгалмаа

Утас: 70332860

Ахлах аудитор: Н.Алтантуяа

Утас: 70333019

ТАБ-ын хаяг:

Архангай аймгийн Аудитын газар

Байршил: Цэцэрлэг хот

Цахим хуудас: audit.mn

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	3
2.1	Оршил	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6	ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТАНД ТОДОРХОЙЛСОН ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	7
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.12	Шилэн дансны мэдээлэл	8
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	10
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	10
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	11
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
3.4	АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	15
3.5	АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	16

1 Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
**АРХАНГАЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**
65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: (976) 7033-3141
E-mail: arkhangai@audit.gov.mn

АРХАНГАЙ АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН
ХЯНАЛТЫН ГАЗРЫН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ Н.ЦЭВЭГДОРЖ ТАНАА

2017.06.07 № 07

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын төсвийн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон, аккруэл сууриар бэлтгэгдсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2.1-д заасан бүрэн эрхийн дагуу Архангай аймгийн Аудитын газар аудит хийлээ.

Мэргэжлийн хяналтын газрын төсөв захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС) түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь төсвийн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл:

Төрийн Аудитын байгууллага нь аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа нотолгоо олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мэргэжлийн хяналтын газрын төсвийн захирагчийн 2016 оны санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуусан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт:

Мэргэжлийн хяналтын газрын төсвийн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар журмуудын дагуу материаллаг алдаагүй үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.УЛАМБАЯР



2 Аудитын тайлан

2.1 Оршил

Мэргэжлийн хяналтын газрын төсвийн захирагч Н.Цэвэгдоржид танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэхь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор *Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.*

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.01.27 - ноос 2017.02.05 – ний хооронд хийж, аудитын тайланг 2017.02.07 - нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Ахлах аудитор Н.Алтантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа төрийн аудитын байгууллагад 2017.01.25-ны өдрийн 02/17 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Аймгийн мэргэжлийн хяналтын газар нь “Монгол Улсын нутаг дэвсгэрт хуулийг сахиулан, хүний болон нийгмийн тогтвортой хөгжил, бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлэх, ирээдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэхэд мэргэжлийн хяналт шалгалтын байгууллагын эрхэм зорилго оршино” гэсэн эрхэм зорилгын дор Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж байна.

Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газар дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:

Тайлант хугацаанд Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газар “МУЗГ-аас 2016 оныг “Хэрэглэгчийн жил” болгосонтой холбогдуулан МХЕГ -аас “Цахим засаглалыг нэвтрүүлэн хяналт шалгалтын давхардал, хүнд суртлыг арилгаж нэгж хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулан ил тод байдлын индексийг нэмэгдүүлэх” зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

Үйл ажиллагааны чиглэлийг Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9-р зүйлд **“хуульд заасны дагуу хууль, тогтоомж болон нийтээр дагаж мөрдөх эрх зүйн бусад актын биелэлтэд хяналт тавих”** гэж тодорхойлсон байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 2 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж дүгнэгдлээ.

Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газар санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд “Интерактив ХХК-ны "Emerald" санхүүгийн программ” хангамжийг ашиглажээ. Уг програм нь Санхүүгийн тайлагналын Олон Улсын стандарт болон Монгол улсын НББ-ийн стандартад нийцсэн тул Сангийн яамнаас ашиглах зөвшөөрөл авсан байна. Тус хувилбар нь төсөвт байгууллагын нягтлан бодогчид өдөр тутмын үйл ажиллагааны анхан шатны мэдээллийг бүртгэх, санхүүгийн мэдээ, тайлан гаргахад зориулагдсан байна.

2.6 ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТАНД ТОДОРХОЙЛСОН ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 19 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.5 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 3 асуудал эрсдэл өндөр, 4 асуудал эрсдэл дунд гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин дунд гэж үнэлэгдсэн байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 3 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих, шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тухайн байгууллага алдагдал тайлагнагдсан тул материаллаг байдлын суурийг орлогоос тооцох нь учир дутагдалтай, нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгөөс тооцох нь зохимжгүй тул материаллаг байдлын суурь үзүүлэлтийг тухайн байгууллагын нийт зардлын дүнгээс тооцох нь зохимжтой гэж үзлээ.

Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 516.8 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь буюу 5.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтийг гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн үе шатанд тооцсон хэмжээнээс өөрчлөөгүй 1 хувиар буюу 5.2 сая төгрөгөөр тооцлоо.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 5 чиглэлээр 8 эрсдэлтэй асуудалд 8 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2016 оны санхүүгийн тайлангийн аудиттай уялдуулан 2016 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийхэд санхүүгийн тайланд хоорондын тооцоо нийлж баталгаажуулаагүй 5.4 сая төгрөгийн түлш халаалтын өрийг тусгасан, мөн байгууллагын хөрөнгөнд бүртгэлтэй 36.4 сая төгрөгийн бараа материалыг эхний хагас жилд тооллогод хамруулаагүй зэрэг нийт 41.8 сая төгрөгийн зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлэн зөрчлийг бүрэн арилгуулж ажилласан. Мөн ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээ бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй үндсэн хөрөнгүүдийг акталж данснаас хасах зөвлөмж хүргүүлж биелэлтийг хангуулсан.

Харин санхүүгийн тайлангийн аудитаар МХЕГ-ын төлбөртэй ажил үйлчилгээний орлогын төлөвлөгөө 3.0 сая төгрөг, түүний гүйцэтгэл 5.4 сая төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгаж тайлагнасныг санхүүгийн тайланд залруулга хийлгэн засууллаа.

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Тус байгууллага нь 2016 онд цалингийн сангаас шүүхийн шийдвэрийн дагуу нийт 6.3 сая төгрөгийг олгосон нь ажлаас халагдсан ажилчдын цалин, НДШ, ХХОАТатвар байна. Энэ нь төлөвлөгдөөгүй зардал бөгөөд энэ хэмжээгээр тухайн байгууллагын зардал хэмнэгдэх боломжтой байжээ.

Аймгийн МХГ-ыг 2017 оны санхүүгийн тайлангийн аудиттай уялдуулан завсрын аудит хийнэ. 2016 оны Санхүүгийн тайлангийн тухайд санхүүгийн байдлын болон өмчийн өөрчлөлтийн тайланд тайлант үеийн үр дүнг өмнөх үеийн үр дүнтэй нийлүүлэн тайлагнасан нь санхүүгийн программд тохируулга хийх шаардлагатайг харуулж байгаа бөгөөд энэ талаар тус байгууллагын нягтлан бодогчтой санал солилцож дараагийн аудитаар анхааран авч үзэхээр тогтлоо.

2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газар өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 458.5 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	458,479,000.00	457,269,658.00	99.6%	- 1209,342.00
1.1	Урсгал зардал	458,479,000.00	457,269,658.00	99.6%	- 1209,342.00
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
2	Зардлыг сахүүжүүлэх эх үүсвэр	458,479,000.00	457,269,658.00	99.6%	- 1209,342.00
2.1	Улсын төсвөөс санхүүжих	458,479,000.00	457,269,658.00	99.6%	- 1209,342.00

Төсөвт зардлын гүйцэтгэл 99.6 хувь буюу нийт дүнгээрээ 1.2 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Үүнд урсгал засвар, тээврийн хэрэгслийн татвар, даатгал, мэдээлэл технологийн үйлчилгээ зэрэг зардлууд 0.2-0.3 сая төгрөгөөр тус тус хэмнэгджээ. Харин байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардлуудыг бүлэг дотор нь гүйлгэн зарцуулсан байна.

Тайлант хугацаанд төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын биелэлт 180% байгаа нь 3.0 сая төгрөгийн өөрийн орлогын төлөвлөгөөтэйгээс тайлант онд лабораторийн үйлчилгээгээр 5.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 2.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэнтэй холбоотой.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 0.2 сая төгрөгийг авч урсгал зардалд зарцуулсан байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тус байгууллагын 2016 оны шилэн дансны мэдээллийг шалгахад хуульд мэдээлэхээр заасан мэдээллүүдийг бүрэн оруулсан байна.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2016 оны жилийн эцсийн байдлаар 100% хувьтай байна.

Зөвлөмжийн биелэлтийг нь аудитын явцад санхүүгийн тайланг үнэн зөв гарган залруулга хийж биелүүлсэн тул албан бичгээр хариу ирүүлээгүй байна.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж **“Зөрчилгүй”** санал дүгнэлт гаргалаа.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

3.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>38,394,449.77</u>	<u>34,432,989.58</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	38,394,449.77	34,432,989.58
351	Түүхий эд материал	4,004,710.00	4,168,404.68
35110	Тусгай зориулалттай материал	1,100,500.00	1,011,500.00
35130	Эм боох материал	2,904,210.00	3,156,904.68
354	Хангамжийн материал	34,389,739.77	30,264,584.90
35410	Бичиг хэргийн материал	2,602,332.04	1,178,810.18
35420	Аж ахуйн материал	15,278,273.00	11,133,232.22
35440	Түлш, шатах тослох материал	1,007,955.00	-
35470	Бусад хангамжийн материал	15,501,179.73	17,952,542.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>515,112,330.76</u>	<u>466,642,153.74</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	515,112,330.76	466,642,153.74
391	Газар		
392	Биет хөрөнгө	515,112,330.76	466,642,153.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	457,000,000.00	457,000,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	22,792,656.90	30,424,964.70
39203	Авто-тээврийн хэрэгсэл	76,530,000.00	58,630,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	51,293,325.16	54,966,684.16
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	97,587,466.03	89,555,231.03
39206	Хуримтлагдсан элэгдэл	62,987,909.99	66,289,041.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,638,355.51	27,198,492.56
39208	Хуримтлагдсан элэгдэл	17,162,664.53	17,304,634.54
39214	Бусад үндсэн хөрөнгө	78,028,206.20	76,792,406.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	69,435,140.40	73,548,651.55
393	Биет бус хөрөнгө	-	-
39301	Програм хангамж	713,000.00	713,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	713,000.00	713,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>553,506,780.53</u>	<u>501,075,143.32</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>575,800.00</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	575,800.00	-
413	Өглөг	575,800.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	575,800.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>552,930,980.53</u>	<u>501,075,143.32</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	552,930,980.53	501,075,143.32
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	658,921,197.91	658,921,197.91
512	Хуримтлагдсан үр дүн	(106,579,649.73)	(158,435,486.94)
51210	Өмнөх үеийн үр дүн	(68,518,315.73)	(68,518,315.73)
51220	Тайлант үеийн үр дүн	(38,061,334.00)	(89,917,171.21)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	589,432.35	589,432.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>553,506,780.53</u>	<u>501,075,143.32</u>

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	518,054,399.82	464,995,850.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,380,900.00	6,298,838.72
120	Нийтлэг татварын бус орлого	4,380,900.00	6,298,838.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,380,900.00	6,298,838.72
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,365,900.00	5,381,700.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	15,000.00	917,138.72
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	513,673,499.82	458,697,012.00
1310	Улсын төсвөөс	513,435,480.00	458,479,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	513,435,480.00	458,479,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	238,019.82	218,012.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		218,012.00
131106	Төсвийн урамшуулал	238,019.82	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	557,831,713.72	497,741,257.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	557,831,713.72	497,741,257.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	516,804,055.72	490,040,215.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	350,472,199.00	328,144,812.00
210101	Үндсэн цалин	307,026,163.00	287,240,612.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,804,000.00	12,804,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	30,642,036.00	28,100,200.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,553,600.00	35,032,200.00
210201	Тэтгэврийн даатгал	37,539,103.00	35,032,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,014,497.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,603,600.00	63,543,466.00
210301	Гэрэл, цахилгаан	5,214,645.00	2,681,065.00
210302	Түлш, халаалт	44,359,164.00	57,486,325.00
210303	Цэвэр, бохир ус	3,642,041.00	1,278,076.00
210304	Байрны түрээс	1,387,750.00	2,098,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,022,001.83	18,459,747.98
210401	Бичиг хэрэг	4,366,786.83	4,609,731.86
210402	Тээвэр, шатахуун	10,754,050.00	9,031,440.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,477,995.00	1,417,474.00
210404	Ном, хэвлэл	66,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	357,170.00	1,801,803.33
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	-
210408	Бараа материал акталсны зардал	-	1,599,298.79
2105	Нормативт зардал	6,528,856.78	5,742,701.41
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,076,576.78	3,560,141.41
210502	Хоол, хүнс	2,452,280.00	2,182,560.00

Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,249,778.81	2,971,099.80
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,342,488.99	-
210604	Урсгал засвар	4,907,289.82	2,971,099.80
2107	Томилолт, зочны зардал	6,921,600.00	3,495,100.00
210702	Дотоод албан томилолт	6,921,600.00	3,495,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,927,548.00	2,304,643.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,362,308.00	800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	208,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	33,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	286,120.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	684,993.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	565,240.00	42,330.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,524,871.30	30,346,444.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	250,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	260,200.00	107,060.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,014,671.30	30,239,384.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,027,658.00	7,701,042.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,668,248.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,668,248.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,689,120.00	1,110,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,521,000.00	810,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,518,620.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,670,290.00	6,591,042.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,670,290.00	6,591,042.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(39,777,313.90)	(32,745,406.44)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,459,020.10	19,110,430.77
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,459,020.10	19,110,430.77
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,459,020.10)	(19,110,430.77)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(41,236,334.00)	(51,855,837.21)

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	530,277,114.82	475,804,457.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,403,762.00	10,656,390.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,403,762.00	10,656,390.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,365,900.00	5,381,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,365,900.00	5,381,700.00
120009	Бусад орлого	3,037,862.00	5,274,690.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	522,873,352.82	465,148,067.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	513,435,480.00	458,479,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	513,435,480.00	458,479,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,413,019.82	218,012.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,175,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		218,012.00
131106	Төсвийн урамшуулал	238,019.82	
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6,024,853.00	6,451,055.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	6,024,853.00	6,451,055.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	530,277,114.82	475,804,457.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	530,277,114.82	475,804,457.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	483,224,603.82	461,652,360.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	350,472,199.00	328,144,812.00
210101	Үндсэн цалин	306,445,699.00	287,240,612.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,804,000.00	12,804,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	31,222,500.00	28,100,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,553,600.00	35,032,200.00
210201	Тэтгэврийн даатгал	38,553,600.00	35,032,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,603,600.00	63,543,466.00
210301	Гэрэл, цахилгаан	5,269,558.00	5,065,904.00
210302	Түлш, халаалт	44,359,164.00	52,467,309.00
210303	Цэвэр, бохир ус	3,587,128.00	3,469,753.00
210304	Байрны түрээс	1,387,750.00	2,540,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,609,600.00	12,857,939.00
210401	Бичиг хэрэг	2,706,180.00	2,082,200.00
210402	Тээвэр, шатахуун	9,409,965.00	8,223,485.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,477,995.00	1,417,474.00
210404	Ном, хэвлэл	66,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	949,460.00	1,134,780.00
2105	Нормативт зардал	6,492,455.00	8,689,310.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,575,500.00	6,459,550.00
210502	Хоол, хүнс	1,916,955.00	2,229,760.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,407,839.82	632,600.00

Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210601	Багаж, техник, хэрэгсэл	238,019.82	-
210604	Урсгал засвар	4,169,820.00	632,600.00
2107	Томилолт, зочны зардал	6,506,300.00	4,070,900.00
210702	Дотоод албан томилолт	6,506,300.00	4,070,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,280,948.00	3,161,943.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,241,700.00	800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	376,679.00	395,220.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	38,500.00	206,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	187,762.00	48,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,950.00	740,123.00
210807	Газрын төлбөр	-	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	77,267.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	508,090.00	722,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,298,062.00	5,519,190.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,037,862.00	5,274,690.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	260,200.00	244,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,052,511.00	14,152,097.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,338,538.00	6,591,042.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	4,338,538.00	6,591,042.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,713,973.00	7,561,055.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,862,396.00	6,370,124.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	162,457.00	80,931.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,110,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,526,900.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,162,220.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3.4 АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	658,921,197.91	2,087,893.35	-69,804,189.73	591,204,901.53
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-212,587.00	-212,587.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	658,921,197.91	2,087,893.35	-70,016,776.73	590,992,314.53
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		-1,498,461.00	1,498,461.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-38,061,334.00	-38,061,334.00
C08	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	658,921,197.91	589,432.35	-106,579,649.73	552,930,980.53
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	658,921,197.91	589,432.35	-106,579,649.73	552,930,980.53
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	658,921,197.91	589,432.35	-106,579,649.73	552,930,980.53
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-89,917,171.21	-89,917,171.21
D09	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	658,921,197.91	589,432.35	-158,435,486.94	501,075,143.32

3.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	458,479,000.00	457,269,658.00	1,209,342.00	99.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	458,479,000.00	457,269,658.00	1,209,342.00	99.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	457,369,000.00	456,159,658.00	1,209,342.00	99.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	328,241,500.00	328,144,812.00	96,688.00	99.97
210101	Үндсэн цалин	287,337,300.00	287,240,612.00	96,688.00	99.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,804,000.00	12,804,000.00	-	100.00
210105	Гэрээт ажлын хөлс	28,100,200.00	28,100,200.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,032,200.00	35,032,200.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	35,032,200.00	35,032,200.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,543,600.00	63,543,466.00	134.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	5,300,000.00	5,065,904.00	234,096.00	95.58
210302	Түлш, халаалт	53,263,600.00	52,909,809.00	353,791.00	99.34
210303	Цэвэр, бохир ус	3,690,000.00	3,469,753.00	220,247.00	94.03
210304	Байрны түрээс	1,290,000.00	2,098,000.00	(808,000.00)	162.64
2104	Хангамж, бараа материалын зардал	12,640,200.00	12,639,927.00	273.00	100.00
210401	Бичиг хэрэг	2,195,700.00	2,029,873.00	165,827.00	92.45
210402	Тээвэр, шатахуун	8,057,800.00	8,057,800.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,251,900.00	1,417,474.00	(165,574.00)	113.23
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргчдийн устгал, ариутгал	-	-	-	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,134,800.00	1,134,780.00	20.00	100.00
2105	Нормативт зардал	8,709,000.00	8,689,310.00	19,690.00	99.77
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,459,000.00	6,439,550.00	19,450.00	99.70
210502	Хоол, хүнс	2,250,000.00	2,249,760.00	240.00	99.99
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл			-	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	937,600.00	632,600.00	305,000.00	67.47
210604	Урсгал засвар	937,600.00	632,600.00	305,000.00	67.47
2107	Томилолт, зочны зардал	4,070,900.00	4,070,900.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	4,070,900.00	4,070,900.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,949,500.00	3,161,943.00	787,557.00	80.06
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	800,000.00	800,000.00	-	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00	-	100.00

Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	630,100.00	395,220.00	234,880.00	62.72
210804	Тээврийн хэрэгслийн татвар	412,200.00	206,100.00	206,100.00	50.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	58,000.00	48,000.00	10,000.00	82.76
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,099,200.00	771,223.00	327,977.00	70.16
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	700,000.00	691,400.00	8,600.00	98.77
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	244,500.00	244,500.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,110,000.00	1,110,000.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,110,000.00	1,110,000.00	-	100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,110,000.00	1,110,000.00	-	100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	458,479,000.00	457,269,658.00	1,209,342.00	99.74
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	458,479,000.00	457,269,658.00	1,209,342.00	99.74
131001	Улсын төсвөөс санхүүжих	458,479,000.00	457,269,658.00	1,209,342.00	99.74
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	38.00	38.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	28.00	26.00	2.00	92.86
620003	Үйлчлэх ажилтан	7.00	9.00	(2.00)	128.57
620004	Гэрээт ажилтан	2.00	2.00	-	100.00